

Mongolian language for foreigners Week 1
Introduction to Mongolia

Сэдэв: “Монгол улсын тухай” лекц №1

Topic: “Introduction of Mongolia”

Сонсох, ярих, унших, бичих
listening, speaking, reading, writing

Mongolian National University arts And Culture
Professor, Basbish.S

Хичээлийн агуулга - Lecture content

1. Монгол улсын тухай ерөнхий ойлголт- General Understanding of Mongolia
2. Дасгал ажлууд- Exercises
3. Шинэ үг хэллэгүүд- New words
4. Гэрийн даалгавар - Homework



Chineeb. (2008 оны 5 сарын 26). *Mongolian Aimags*. [wikimedia.org:
https://commons.wikimedia.org/wiki/File:Mongolian_Aimags,_Mongolia.png](https://commons.wikimedia.org/wiki/File:Mongolian_Aimags,_Mongolia.png)

Дасгал 1. Асуултыг уншаарай.
Exercise 1. Read the questions.

1. Монгол улсын газар нутгийн талаар ярина уу.
2. Монгол орон хэдэн улиралтай вэ? Хамгийн хүйтэн, хамгийн халуун үе хэзээ вэ?
3. Монгол улсын хүн ам, үндэстэн, ястны талаар ярина уу. (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хууд. 6)

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

General Understanding of Mongolia

Дасгал 2. Сонсгол. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.

Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс- Choose from following words: дөрвөн улиралтай, дундаж наслалт, ерөнхийлөгч, бөө мөргөл, далайд гарцгүй, дунджаар, хойд хагасын, ерөнхий сайд, нүүдлийн шувуу, далайн түвшнээс

Газар нутаг: Монгол улс Төв Азид оршдог бөгөөд Оросын Холбооны Улс (ОХУ), Бүгд Найрамдах Хятад Ард Улстай (БНХАУ) хиллэдэг, 1) далайд гарцгүй улс юм.

Газар нутгийн хэмжээ: 1,565,000 х.д.км. Хилийн нийт урт: 8,158 км. (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хууд. 6)



Монгол орны хилийн цэгүүд. (2017 оны 5 сарын 9). [blogspot.com: http://bglmgl.blogspot.com/p/blog-page.html](http://bglmgl.blogspot.com/p/blog-page.html)

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

General Understanding of Mongolia

Дасгал 2. Сонсгол. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.

Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс- Choose from following words: дөрвөн улиралтай, дундаж наслалт, ерөнхийлөгч, бөө мөргөл, далайд гарцгүй, дунджаар, хойд хагасын, ерөнхий сайд, нүүдлийн шувуу, далайн түвшнээс

Хилийн захын цэгүүд: баруун цэг Мааньт уулаас зүүн цэг Модот хамар хүртэл 2,392 км, хойд цэг Монгол шарын даваанаас урд цэг Орвог гашууны бор толгой хүртэл 1,259 км.

2) _____ дээш дундаж өндөр 1580 м. Хамгийн өндөр цэг 4,374 м. (Алтай таван богд уулын Хүйтэн уул), хамгийн нам цэг нь 580 м. (Хөх нуурын хотгор). (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хууд. 6)



Монгол орны хилийн цэгүүд. (2017 оны 5 сарын 9). [blogspot.com:
http://bglmgl.blogspot.com/p/blog-page.html](http://bglmgl.blogspot.com/p/blog-page.html)

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ *General Understanding of Mongolia*

Дасгал 2. Сонсгол. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү. Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс- Choose from following words: дөрвөн улиралтай, дундаж наслалт, ерөнхийлөгч, бөө мөргөл, далайд гарцгүй, дунджаар, хойд хагасын, ерөнхий сайд, нүүдлийн шувуу, далайн түвшнээс

Уур амьсгал: Монгол орон дэлхийн бөмбөрцгийн 3) _____ сэрүүн бүсэд орших ба хуурай газрын эрс тэс, сэрүүвтэр уур амьсгалтай.

Салхи ихэвчлэн баруун ба хойт зүгээс салхилна. Хамгийн хүйтэн нь нэгдүгээр сар бөгөөд сарын дундаж температур -35° , хамгийн их нь -50° (Увс нуур). Хамгийн халуун нь долоодугаар сар бөгөөд сарын дундаж температур $+25^{\circ}$, хамгийн их нь $+40,8^{\circ}$ (Сайншанд) байдаг. 10 дугаар сараас 4 дүгээр сар хүртэл цастай байдаг. Жилийн 4) _____. (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хууд. 6

Алтан овоо. (2015 оны 8 сарын 2). <https://www.assa.mn/a/31296>



МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ *General Understanding of Mongolia*

**Дасгал 2. Сонсгол. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words**

Нөхөх үгс- Choose from following words: дөрвөн улиралтай, дундаж наслалт, ерөнхийлөгч, бөө мөргөл, далайд гарцгүй, дунджаар, хойд хагасын, ерөнхий сайд, нүүдлийн шувуу, далайн түвшнээс

Нийт нутгийн ихэнх хэсгийг өндөр уул нуруу эзэлнэ. Монгол оронд 140 гаруй зүйлийн амьтан, 390-ээд зүйлийн шувуу бий. Шувуудыг 5) _____, суурин (өвөлждөг) шувуу гэж хоёр ангилна. (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хууд. 7)

Алтан овоо. (2015 оны 8 сарын 2). <https://www.assa.mn/a/31296>




МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

General Understanding of Mongolia

Дасгал 2. Сонсгол. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс- Choose from following words: дөрвөн улиралтай, дундаж наслалт, ерөнхийлөгч, бөө мөргөл, далайд гарцгүй, дунджаар, хойд хагасын, ерөнхий сайд, нүүдлийн шувуу, далайн түвшнээс

Засаг захиргаа: Монгол улс 21 аймаг, 1 нийслэл хотоос бүрдэнэ. Нийслэл хот нь Улаанбаатар. Аймаг нь дотроо сум, багаас бүрдэнэ. Харин нийслэл нь дүүрэг, хорооноос бүрдэнэ. Монгол улсын 21 аймагт нийт 330 гаруй сум байна. Нэг сум 6) _____ 3000-5000 хүнтэй. (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хууд. 7)



МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ
General Understanding of Mongolia

Дасгал 2. Сонсгол. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс- Choose from following words: дөрвөн улиралтай, дундаж наслалт, ерөнхийлөгч, бөө мөргөл, далайд гарцгүй, дунджаар, хойд хагасын, ерөнхий сайд, нүүдлийн шувуу, далайн түвшнээс

Хүн ам: 3,3 сая хүн амтай (2020 оны 1-р сар). 1 х.д.км -т 1.5 хүн оногдоно. Нийт хүн амын 50% гаруй нь хот суурин газар амьдардаг. 20 гаруй үндэстэн, ястнаас бүрдэнэ (2014 оны статистик мэдээгээр 25 ястан, 2 үндэстэн бүртгэгдсэн).

7) _____ эрэгтэй 62, эмэгтэй 65. Хүн амын 80% гаруй нь халх монгол, үлдсэн хувь нь казак, буриад зэрэг бусад ястан байдаг. Албан ёсны хэл монгол хэл. (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хууд. 7)

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ
General Understanding of Mongolia

Дасгал 2. Сонсгол. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс- Choose from following words: дөрвөн улиралтай, дундаж наслалт, ерөнхийлөгч, бөө мөргөл, далайд гарцгүй, дунджаар, хойд хагасын, ерөнхий сайд, нүүдлийн шувуу, далайн түвшнээс

Шашин шүтлэг: Голлох шашин буддын шашин болон 8) _____. Мөн христ, лалын гэх мэт бусад шашин ч бий.

Мөнгөн тэмдэгт: Монгол улсын мөнгөн тэмдэгт нь төгрөг.

Ханш нь: 1\$ = 3245 төгрөг (2022 оны 9 дүгээр сарын байдлаар) (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хууд. 6)

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

General Understanding of Mongolia

Дасгал 2. Сонсгол. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү. **Exercise 2. Listen and fill the missing words**

Нөхөх үгс- Choose from following words: дөрвөн улиралтай, дундаж наслалт, ерөнхийлөгч, бөө мөргөл, далайд гарцгүй, дунджаар, хойд хагасын, ерөнхий сайд, нүүдлийн шувуу, далайн түвшнээс



Монгол улсын төрийн далбаа. (2023 оны 1 сарын 26). wikipedia.org:
https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D0%A3%D0%BB%D1%81%D1%8B%D0%BD_%D1%82%D3%A9%D1%80%D0%B8%D0%B9%D0%BD_%D0%B4%D0%B0%D0%BB%D0%B1%D0%B0%D0%B0

Төрийн байгууламж: Төрийн тэргүүн нь 9) _____. Ард түмэн ерөнхийлөгчийг бүх нийтийн сонгуулиар 4 жилийн хугацаатай сонгоно. Засгийн газрын тэргүүн нь 10) _____. Хууль тогтоох дээд байгууллага нь Улсын Их Хурал. УИХ нь 76 гишүүнээс бүрдэх бөгөөд мөн ард түмэн тэднийг бүх нийтийн сонгуулиар 4 жилийн хугацаатай сонгоно.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын (НҮБ) гишүүн: Монгол Улс нь 1946 онд анх НҮБ-д элсэх хүсэлт гаргаж, 1961 онд НҮБ-ын 101 дэх орон болон элсч байжээ. (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хууд. 7)

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ
General Understanding of Mongolia

Дасгал 3. Тоог үсгээр бичиж, өгүүлбэрийг гүйцээнэ үү.

Exercise 3. Write the numbers in letters and complete the sentence

1. Монгол орон жилийн (4) ...**дөрвөн**....улиралтай.
2. Монгол улс (21) аймаг, (1) нийслэлтэй.
3. Монголын баруун цэг Мааньт уулаас зүүн цэг Модот хамар хүртэл (2,392 км)
.....километр үргэлжилдэг.
4. Мөн хойд цэг Монгол шарын даваанаас урд цэг Орвог гашууны бор толгой хүртэл (1,259 км)
..... километр үргэлжилдэг. (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021,
хуудсд. 7-8)

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ
General Understanding of Mongolia

Дасгал 3. Тоог үсгээр бичиж, өгүүлбэрийг гүйцээнэ үү.

Exercise 3. Write the numbers in letters and complete the sentence

1. Хамгийн өндөр цэг Алтай таван богд уулын Хүйтэн уул нь (4,374 м)
.....метр өндөр.
2. Хамгийн нам цэг нь Хөх нуурын хотгор нь (580 м)метр өндөр.
3. Хамгийн хүйтэн сар нь нэгдүгээр сар бөгөөд сарын дундаж температур (-35°).....хэмд хүрдэг. Хамгийн их нь (-50°) (Увс нуур).
4. Хамгийн халуун сар нь долоодугаар сар бөгөөд сарын дундаж температур (+25°)
.....хэмд хүрдэг. Хамгийн их нь (+40,8°)..... (Сайншанд)
байдаг. (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хуудсд. 7-8)

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ
General Understanding of Mongolia

Дасгал 4. А. Өгөгдсөн үгсийг тайлбартай нь тохируулна уу.
Exercise 4. Match following words to its explanation

- | | |
|------------|---|
| 1. Улс | а) Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хамгийн том нэгж |
| 2. Нийслэл | б) Улсын төв хот, төрийн эрх барих болон төрийн захиргааны дээд байгууллага байрладаг. |
| 3. Хот | в) Барилга байшин, үйлдвэр, худалдаа засаг захиргааны байгууллага байрладаг хүн ам олноор суурьшсан газар |
| 4. Аймаг | г) Засаг захиргааны хамгийн бага нэгж |
| 5. Сум | д) Өөрийн төр засаг, харьяат иргэд бүхий тусгаар тогтносон газар нутаг |
| 6. Баг | е) Аймгийн дараах засаг захиргааны нэгж |

1.....2.....3.....4..**B**.....5.....6..... (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хууд. 9)

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ
General Understanding of Mongolia

Дасгал 4 Б. Дээрх үгсийг ашиглан өгүүлбэрийг гүйцээж бичнэ үү.
Exercise 4 B. Complete the sentence using above words

1. Монгол ...улс.....ОХУ, БНХАУ-тай хиллэдэг.
2. Монгол улсынбол Улаанбаатар хот юм.
3. Монгол улсад Дархан, Эрдэнэт, Улаанбаатар гэсэн гурван.....байдаг.
4. Хамгийн том.....бол Өмнөговь юм.
5. Монгол улс 21, 330 –тай.³
6. Манай өвөө Хөвсгөл.....-ын/-ийн Цагаан-Уул -ын/-ийн Агар-д/т амьдардаг. (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хууд. 9)

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

General Understanding of Mongolia

Дүрэм: Тийн ялгалын нөхцөл – Grammar, Suffix of noun cases

№	Тийн ялгал	Асуулт	Нөхцөл
1	Нэрлэх	Хэн?юу?	0 бүтээвэр
2	Харъяалах	Хэний? Юуны?	-ы,ийн,н,ын,ий
3	Өгөх орших	Хэнд? Юунд?	-д,т
4	Заах	Хэнийг? Юуг?	-ийг,ыг,г
5	Гарах	Хэнээс? Юунаас?	-аас,-ээс,-оос,-өөс
6	Үйлдэх	Хэнээр? Юунаар?	-аар,-ээр,-оор,-өөр
7	Хамтрах	Хэнтэй? Юутай?	-тай,тэй,той
8	Чиглэх	Хэн рүү? Юу рүү?	-рүү,-рүү

Манай өвөө Хөвсгөл.....аймаг-ын/-ийн Цагаан-Уул
.....сум-ын/-ийн Агарбаг-д/т амьдардаг.

Харъяалахын тийн ялгал нь “-ийн, -ын, -ий, -ы, н” хэлбэрүүдтэй байна. Эдгээрээс “-ын, -ийн” нөхцөлийг гийгүүлэгч, богино, эгшгээр төгссөн үгэнд дагуулна. “-ы, -ий” нөхцөлийг тогтвортой, тогтворгүй “н” гийгүүлэгчийн дараа эгшиг ялгаж дагуулна. “-н” нөхцөлийг хос эгшгээр төгссөн үгэнд дагуулна. (Munkhtsetseg. A, Delgermaa.Kh, 2013, хууд. 18)

Өгөх оршихын тийн ялгал - д/т – в,с,г,р гийгүүлэгчийн дараа –т нөхцөлийг, бусад гийгүүлэгчид болон эгшгээр төгссөн үгийн дараа –д нөхцөлийг залгана. (Munkhtsetseg. A, Delgermaa.Kh, 2013, хууд. 36)

Ulziimanlai. (2011 оны May 10).

<https://www.slideshare.net/ulziimanlai/ss-7907402>.

slideshare: <https://www.slideshare.net/ulziimanlai/ss-7907402>-ээс Гаргасан

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

General Understanding of Mongolia

Дүрэм: Тийн ялгалын нөхцөл – Grammar, Suffix of noun cases

Монгол улс 21..... аймаг, 330 сум **-тай.**³

№	Тийн ялгал	Асуулт	Нөхцөл
1	Нэрлэх	Хэн?юу?	О бүтээвэр
2	Харъяалах	Хэний? Юуны?	-ы,ийн,н,ын,ий
3	Өөх орших	Хэнд? Юунд?	-д,т
4	Заах	Хэнийг? Юуг?	-ийг,ыг,г
5	Гарах	Хэнээс? Юунаас?	-аас,-ээс,-оос,-өөс
6	Үйлдэх	Хэнээр? Юунаар?	-аар,-ээр,-оор,-өөр
7	Хамтрах	Хэнтэй? Юутай?	-тай,тэй,той
8	Чиглэх	Хэн рүү? Юу рүү?	-рүү,-рүү

Хамтрахын тийн ялгал **-тай**³: Өгүүлбэрт эдгээрийг эгшиг зохицох ёсоор дагуулна. Жишээ нь: ах-ахтай, ном-номтой, өөх-өөхтэй.
(Munkhtsetseg. A, Delgermaa.Kh, 2013, p. 76)

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

General Understanding of Mongolia

Дүрэм: Үг товчлох тухай – Grammar, abbreviation

- Оросын Холбооны Улс- ОХУ
- Бүгд Найрамдах Хятад Ард Улс - БНХАУ
- Нэгдсэн Үндэстний Байгууллага – НҮБ
- Улсын Их Хурал - УИХ

Эхний үсгээр хураах дүрмээр бичигдсэн үгс. (Нарантуяа,Ш, 2018, хууд. 36)

- Хавтгай дөрвөлжин километр- х.д.км
- Километр- км
- Метр- м

Хэмжигдэхүүн заасан нэрийг товчилсон хэлбэрүүд

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

General Understanding of Mongolia

Дасгал 6. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.
Exercise 6. Discuss about following questions and review your understanding

Одоо бүгдээрээ ойлголтоо шалгаж,
асуултад хариулцгаая:



1. Монгол улсын газар нутгийн хэмжээ хэд вэ? Нэг х.д.км -т хэдэн хүн оногдох вэ?

- *Монгол улсын газар нутгийн хэмжээ 1,565,000 х.д.км. Нэг х.д.км -т 1.5 хүн оногдоно.*

2. Монголд хэдэн улирал байдаг вэ? Нэрлэнэ үү!

- *Монголд 4 улирал байдаг. Өвөл, хавар, зун, намар*

3. Монгол улс аль тивд оршдог вэ? Ямар ямар улстай хиллэдэг вэ?

- *Монгол улс Ази тивд оршдог. ОХУ, БНХАУ-тай хиллэдэг.* (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хуудсд. 7-8)

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

General Understanding of Mongolia

Дасгал 6. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.
Exercise 6. Discuss about following questions and review your understanding

Одоо бүгдээрээ ойлголтоо шалгаж, асуултад хариулцгаая:

4. Монгол улсын хүн ам, үндэстэн, ястны талаар ярина уу!

- *Монгол улс 3 сая 300 мянган хүн амтай. Халх, дөрвөд, баяд, буриад зэрэг олон үндэстэн ястанд хуваагддаг.*

5. Монгол улсын засаг захиргааны нэгжүүдийг нэрлэнэ үү!

- *Хот, аймаг, сум, багт хуваадаг.* (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хуудсд. 7-8)



Source: <https://www.vecteezy.com/vector-art/2563696-teach-school-and-education-student-reading-a-book-silhouette-style-icon>

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

General Understanding of Mongolia

Дасгал 6. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.
Exercise 6. Discuss about following questions and review your understanding

Одоо бүгдээрээ ойлголтоо шалгаж, асуултад хариулцгаая:



6. Монгол улсын хилийн нийт урт хэд вэ? Хилийн 4 захыг нэрлэнэ үү?

- *Баруун цэг Мааньт уулаас зүүн цэг Модот хамар хүртэл 2,392 км, хойд цэг Монгол шарын даваанаас урд цэг Орвог гашууны бор толгой хүртэл 1,259 км.*

7. Монгол улсын хамгийн өндөр, хамгийн нам цэгийг нэрлэнэ үү?

- *Хамгийн өндөр цэг 4,374 м (Алтай таван богд уулын Хүйтэн уул), хамгийн нам цэг нь 580 м. (Хөх нуурын хотгор).* (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хуудсд. 7-8)

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

General Understanding of Mongolia

Дасгал 6. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.
Exercise 6. Discuss about following questions and review your understanding

Одоо бүгдээрээ ойлголтоо шалгаж, асуултад хариулцгаая:



8. Монголд хэдэн төрлийн ан амьтан, жигүүртэн шувууд байдаг вэ?

- *Монголд 140 гаруй зүйлийн амьтан, 390-ээд зүйлийн шувуу байдаг.*

9. Монгол улс хэдэн аймаг, сумтай вэ?

- *Монгол улс 21 аймаг, 330 гаруй сумтай.* (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хуудсд. 7-8)

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

General Understanding of Mongolia

Дасгал 6. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.
Exercise 6. Discuss about following questions and review your understanding

Одоо бүгдээрээ ойлголтоо шалгаж, асуултад хариулцгаая:

10. Монгол улсын төрийн тэргүүн хэн бэ? Түүнийг хэн сонгодог вэ?

- *Монгол улсын төрийн тэргүүн бол ерөнхийлөгч. Түүнийг ард түмэн сонгоно.*

11. Монгол улсын УИХ хэдэн гишүүнтэй вэ? Тэднийг яаж сонгодог вэ?

- *Монгол улсын УИХ 76 гишүүнтэй. Тэднийг ард түмэн бүх нийтийн сонгуулиар сонгоно.* (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хуудсд. 7-8)



МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ
General Understanding of Mongolia

Гэрийн даалгавар- Homework (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хууд. 11)

Мэдлэг шалгах тесст- Test

1. Монгол улс ямар тивд оршдог вэ?

- А. Ази Б. Европ В. Африк Г. Америк

2. Монгол улсын нийслэл хот нь

- А. Улаанбаатар Б. Эрдэнэт В. Дархан Г. Ховд

3. Монгол улсын мөнгөн тэмдэгт нь.....

- А. Төгрөг Б. Мөнгө В. Доллар Г. Евро

4. Монгол улсын хүн амын 80 гаруй хувийгястан эзэлдэг.

- А. Захчин Б. Буриад В. Халх Г. Торгууд

5. Монгол улс засаг захиргааны хувьд аймаг, нийслэл хотоос бүрдэнэ.

- А. 20,1 Б. 20,2 В. 21,1 Г. 21,2

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ
General Understanding of Mongolia

Гэрийн даалгавар- Homework (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хууд. 11)

Мэдлэг шалгах тесст- Test

6. Монгол улс гаруй ястнаас бүрдэнэ.

A. 10 Б. 20 В. 30 Г. 40

7. Монгол оронд төрлийн ан амьтан, Төрлийн жигүүртэн шувууд бий.

A. 390, 140 Б. 140, 390 В. 340, 190 Г. 190, 340

8. Монгол улс онд НҮБ-ын 101 дэх гишүүн орон болон элсэж байжээ.

A. 1921 Б. 1911 В. 1991 Г. 1961

9. Монголчуудын голлох шашин нь

A. Будда, Христ Б. Будда, лал В. Будда, бөө Г. Будда католик

10. Монгол улсын албан ёсны хэл нь

A. Монгол хэл Б. Англи хэл В. Кирилл бичиг Г. Монгол бичиг

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

General Understanding of Mongolia

Гэрийн даалгавар- Homework (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, р. 10)

Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.

Memorize the new vocabularies and understand the meaning

1. Аймаг – province
2. Албан ёсны хэл – official language
3. Ан амьтан – wild animal
4. Ард түмэн – people
5. Баг –smallest local administrative
6. Бөө мөргөл – shamanism
7. Буддын шашин – buddhism
8. Бүрдэх – to consist of
9. Бүртгэгдэх – to be registered
10. Бүх нийтийн – public
11. Газар нутаг – territory
12. Гишүүн – member

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

General Understanding of Mongolia

Гэрийн даалгавар- Homework (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, р. 10)

- *Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.*

Memorize the new vocabularies and understand the meaning

1. Голлох шашин – main religion
2. Далайд гарцгүй – landlocked
3. Далайн түвшнээс дээш – above sea level
4. Дундаж (дунджаар) – average (on average)
5. Дундаж наслалт – average life expectancy
6. Дүүрэг – district
7. Дэлхийн бөмбөрцөг – globe
8. Ерөнхий сайд – prime minister
9. Ерөнхийлөгч – president
10. Жигүүртэн шувуу – bird
11. Засгийн газар – government
12. Зах, хязгаар – edge

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

General Understanding of Mongolia

Гэрийн даалгавар- Homework (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, р. 10)

- *Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.*

Memorize the new vocabularies and understand the meaning

1. Зүйл (төрөл зүйл) – species
2. Мөнгөн тэмдэгт – currency
3. Нийслэл хот – capital city
4. НҮБ – the UN
5. Нүүдлийн шувуу – migratory birds
6. Х.д.км – square km
7. Төгрөгийн ханш – rate of tugrig
8. Хил, хиллэх – border, to border
9. Хойд хагас – northern hemisphere
10. Хороо –subdistrict
11. Хувь – portion
12. Хууль тогтоох байгууллага – legislature

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

General Understanding of Mongolia

Гэрийн даалгавар- Homework (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, р. 10)

- *Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.*

Memorize the new vocabularies and understand the meaning

1. Хүн ам – population
2. Хүсэлт гаргах – to request
3. Салхилах – to blow
4. Сонгууль – election
5. Сонгох – elect
6. Статистик мэдээгээр – according to statistics
7. Сум – middle local administrative division between province and bag
8. Суурин шувуу – non-migratory birds
9. Сэрүүн бүс (халуун бүс)– polar region (tropics)
10. Төрийн тэргүүн – a head of state
11. Улсын Их Хурал – parliament
12. Уул нуруу – mountain range
13. Элсэх – to join, to enter
14. Ястан – ethnic group

НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ-REFERENCES

Ном зүй

Bogomolov.PL. (2008 оны 7 сарын 12). Mongolia sum map.png. wikimedia.org:

https://commons.wikimedia.org/wiki/File:Mongolia_sum_map.png

Chineeb. (2008 оны 5 сарын 26). Mongolian Aimags. wikimedia.org:

https://commons.wikimedia.org/wiki/File:Mongolian_Aimags,_Mongolia.png

Munkhtsetseg. A, Delgermaa.Kh. (2013). Goldenkey to Mongolian- Гадаад хүнд зориулсан монгол хэлний CD-тэй сурах бичиг.

Улаанбаатар: МУИС Пресс хэвлэлийн газар.

Ulziimanlai. (2011 оны May 10). Тийн ялгалын нөхцөл. www.slideshare.net:

<https://www.slideshare.net/ulziimanlai/ss-7907402>

Алтан овоо. (2015 оны 8 сарын 2).

<https://www.assa.mn/a/31296>

Монгол орны хилийн цэгүүд. (2017 оны 5 сарын 9). blogspot.com:

<http://bglmgl.blogspot.com/p/blog-page.html>

Монгол улсын төрийн далбаа. (2023 оны 1 сарын 26). wikipedia.org:

https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D0%A3%D0%BB%D1%81%D1%8B%D0%BD_%D1%82

[_%D3%A9%D1%80%D0%B8%D0%B9%D0%BD_%D0%B4%D0%B0%D0%BB%D0%B1%D0%B0%D0%B0](https://mn.wikipedia.org/wiki/%D0%A9%D1%80%D0%B8%D0%B9%D0%BD_%D0%B4%D0%B0%D0%BB%D0%B1%D0%B0%D0%B0)

Мөнхцэцэг, Г., Орхон, Б. (2021). Монгол орон судлал. Улаанбаатар: Линограф ХХК.


Нарантуяа,Ш. (2018). Эх хэл-Эрдмийн түлхүүр. 36: Удам соёл ХХК.

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

General Understanding of Mongolia

Гэрийн даалгавар- Homework (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, р. 10)

- *Дээрх сэдэвт гарсан үг хэллэгүүдийг ашиглан өөрийн орны талаар бичээрэй.*
- *Write about your country using the words from the topic above.*



Дараагийн хичээл хүртэл баяртай!

Source:

https://www.freepik.com/premium-vector/cartoon-teacher-teaching-class-vector-flat-concept-illustration_23745498.htm